

БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны үндсэн үр дүнг тархаах семинар

Н. ДОЛЖИНСҮРЭН

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
ахлах статистикч*

2018.06.14

БУСАД БУЮУ ХАМТРАГЧААС БУСАД ХҮМҮҮС

Судалгааны үндсэн зорилтуудын нэг: Бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хүчирхийллийн тархалтыг судалж, тодорхойлох нь байсан.

- Гэр бүлийн гишүүд
 - Эцэг, эх,
 - Ах, эгч, дүү,
 - Хадмууд (аав, ээж, ах, эгч, дүү гм)
 - Гэр бүлийн бусад гишүүд (хойд аав, ээж, тэдний хүүхдүүд)
- Найз, нөхөд
- Танил хүн
- Эрх мэдэл бүхий албан тушаалтан
 - Цагдаа,
 - Багш,
 - Шашны удирдагч
- Огт танихгүй хүн

БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

2017 оны 5, 6 сар

← Амьдралын туршид
(15 наснаас хойш)

2016 оны 5, 6 сар

2017 оны 5, 6 сар

← Одоо үе
(сүүлийн 12 сар)

Төрснөөс

15 нас

← Хүүхэд байх үеийн дарамт
(15 наснаас өмнөх)

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчаас бусад этгээд эмэгтэйн биед ямар нэг байдлаар халдсан, зодсон (15 наснаас хойш)


БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хамтрагчаас бусад этгээд эмэгтэйд хүсээгүй байхад нь хүчээр ямар нэгэн бэлгийн үйлдэл хийлгүүлсэн (15 наснаас хойш)


Хүүхэд байхад нь (15 наснаас өмнө) үйлдсэн бэлгийн хүчирхийлэл

Хамтрагчаас бусад этгээд эмэгтэйд 15 наснаас нь өмнө ямар нэгэн бэлгийн чанартайгаар халдах эсвэл хүсээгүй байхад нь ямар нэгэн бэлгийн үйлдэл хийлгүүлсэн байх

БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ



ТАВАН ЭМЭГТЭЙ
ТУТМЫН НЭГ НЬ
амьдралдаа, ХОРИН
ЭМЭГТЭЙ ТУТМЫН
НЭГ нь сүүлийн 12
сард хамтрагчаас
бусад хүмүүсийн
үйлдсэн бие
МАХБОДЫН
ХҮЧИРХИЙЛЭЛД
өртжээ.



БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

15 наснаас хойш


17.3%

Эмэгтэйчүүдийн **17.3%** нь амьдралдаа **4.5%** нь сүүлийн 12 сард бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.




ХҮЧИРХИЙЛЛИЙН НҮЦГЭН ҮНЭН

БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ





■ Амьдралдаа ■ Сүүлийн 12 сард



МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИД

Эмэгтэйчүүдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэгч (амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь)



ХҮЧИРХИЙЛЛИЙН НҮЦГЭН ҮНЭН

Чанарын судалгаа

Гүнзгийрүүлсэн ярилцлага:

Манай ээж намайг аяга хагалсан ч зодно, юм хум авч шиднэ, аавд уурласан уураа надад гаргаж байнга үхтэл минь зоддог байсан. Тэр бас миний хамрыг минь хүртэл хугалж байсан.

15-19 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас

Манай гэр бүлийн хувьд эдийн засгийн байдал тэгш бус байсан болохоор аав минь ээжид уурласан уураа надад гаргадаг байсан. Би аавдаа эмнэлэгт хэвтэх хүртлээ зодуулж байсан.

15-34 настай ЛГБТ эмэгтэйн ярианаас

Би эгчээс нуугдаж сургуульдаа явдаг, намайг үйлчлэгч хий гээд байдаг юм. Сургуульдаа явж байгаад, баригдаад эгчдээ зодуулсан.

15-34 насны бүлгийн эмэгтэйчүүдийн ярилцлагаас


БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЙЛДЭЛ

■ Амьдралдаа ■ Сүүлийн 12 сард



Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэл

Боловсролын түвшин



Хөдөлмөр эрхлэлтийн байдал



Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл




7 ЭМЭГТЭЙ ТУТМЫН **1**

НЬ амьдралдаа /багадаа нэг удаа/ бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байхад сүүлийн 12 сард **2.6%** нь өртсөн байна.



БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДЭГДСЭН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ



ХҮЧИРХИЙЛЛИЙН НҮЦГЭН ҮНЭН


БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бэлгийн хүчирхийллийн үйлдэл

Дунд хэлбэрийн хүчирхийлэлд хүсээгүй байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдах, хүсээгүй байхад биед нь хүрэх, өөрийн нууц хэсэгтээ хүчээр хүргүүлэх зэрэг үйлдлүүдийг хамааруулна.


Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд хүчээр бэлгийн харьцаанд орох, архи, мансууруулах бодис хэрэглэсэн үед бэлгийн харьцаанд орох, нэгээс дээш хүнтэй нэгэн зэрэг бэлгийн харьцаанд хүчээр орох зэрэг үйлдлүүдийг хамааруулсан юм.

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд (Амьдралдаа – 15 наснаас хойш) өртсөн эмэгтэйчүүд




Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд (Амьдралдаа – 15 наснаас хойш) өртсөн эмэгтэйчүүд

Хүнд хэлбэрийн хүчирхийлэл



■ Нэг ■ Цөөн ■ Олон

Дунд хэлбэрийн хүчирхийлэл



■ Нэг ■ Цөөн ■ Олон

Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэл, үйлдсэн газар (байршлыг хувиар илэрхийлэв), хүчирхийллийн хэлбэрээр

Байршил	Хүнд хэлбэрийн (N=234)	Дунд хэлбэрийн (N=723)
Өөрийн гэрт	65.0	12.6
Хээр газар, ой мод, цэцэрлэгт хүрээлэнд	10.9	8.1
Зочид буудал/ амралтын газарт	4.7	7.8
Гадаа/гудамжинд	4.1	14.3
Ажил дээр	4.0	13.6
Өөр хүний гэрт	2.9	7.9
Түүний гэрт	2.5	6.6
Машинд	1.8	3.3
Баар, цэнгээний газарт	1.6	7.2
Сургуулийн орчинд	.7	12.0
Бусад	1.8	6.7
Бүгд	100.0	100.0

Бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл нь гадаа гудамжинд (14.3%), ажил дээр (13.6%), өөрийн гэрт (12.6%), сургуулийн орчинд (12%) ихэвчлэн болдог байна.

Харин хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл нь эмэгтэйн өөрийн гэрт (65.0%) , хээр газар, ой мод, цэцэрлэгт хүрээлэнд (10.9%) болдог байна.

Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүд уг хүчирхийллийг цагдаад мэдээлсэн байдал




Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн

10.2% нь

хүчирхийллийн талаар цагдаад мэдэгдсэн байна.

- Цагдаад мэдээлсэн
- Цагдаад мэдээлээгүй



- Судалгаагаар хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол 21 мэдээлэгдсэн бөгөөд тэдний зөвхөн 10.2 хувь нь хүчирхийлэлд өртсөн тухайгаа цагдаад мэдэгдсэн байна.
- Цагдаагийн байгууллагад мэдээлсэн 21 эмэгтэйгээс 9 нь хэрэг үйлдэгчийг баривчлаагүй, 8 нь хэрэгтнийг баривчилж, шийтгэсэн, 3 нь хэрэгтнийг баривчилсан гэхдээ шийтгээгүй гэж хариулсан байна.

ХҮҮХЭД НАСАНД БУЮУ 15 ХҮРТЭЛХ НАСАНДАА ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭМЭГТЭЙЧҮҮД

- Эмэгтэйчүүдээс 15 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг тодруулсан ба энэ нь маш эмзэг сэдэв учраас судалгаанд асуулга хэлбэрээр асуухаас гадна ярилцлагын төгсгөлд нууцлалыг хангасан карт өгч, хариулт авах гэсэн хоёр 2 өөр аргыг ашигласан.

Гунигтай царайг тэмдэглэх тохиолдол

Хөх эсвэл бэлэг эрхтэнд хүрэх
Хүсээгүй байхад бэлгийн хүчирхийлэлтэй
холбоотой зураг үзүүлэх
Өөрийнхөө бэлэг эрхтэнд хүргэх
Бэлгийн харьцаанд орох гэж оролдох эсвэл
орох

Баяртай царайг тэмдэглэх тохиолдол

Дээрх зүйлс тохиолдож байгаагүй бол
баяртай царайг тэмдэглэх






10 ЭМЭГТЭЙ ТУТМЫН 1

ЭМЭГТЭЙ НЬ

Хүүхэд байхдаа **бэлгийн**
хүчирхийлэлд өртсөн байна.

Хүүхэд насандаа (15 хүртэлх насандаа) бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хот, хөдөөгийн байршлаар

Бэлгийн хүчирхийлэл (асуулга болон карт)




Хүүхэд насандаа
(15 хүртэлх насандаа)
бэлгийн хүчирхийлэлд
өртсөн гэж
судалгааны үед
мэдэгдсэн
эмэгтэйчүүд,
үйлдэгчээр



Эмэгтэйчүүд анх бэлгийн харьцаанд орсон нас, байршлаар


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн ихэнх (55.3 хувь) нь 18-21 насандаа анх бэлгийн харьцаанд орсон байна. Харин цөөнх буюу 0.8 хувь нь 15 нас хүрэхээс өмнө, 10 эмэгтэй тутмын нэг (10.2 хувь) нь 15-17 насандаа анх бэлгийн харьцаанд оржээ.




Анх бэлгийн харьцаанд орохдоо хүсэж байсан эсэх

- Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс анх бэлгийн харьцаанд өөрөө хүсч орсон уу эсвэл хүчээр орсон уу гэдгийг лавласан бөгөөд тэдний ихэнх (86.5 хувь) нь анх удаа бэлгийн харьцаанд орохдоо өөрөө зөвшөөрсөн гэж хариулжээ. **Арван эмэгтэй тутмын нэг (10.2 хувь)** нь хүсээгүй гэхдээ бэлгийн харьцаанд орсон, **2.9 хувь нь** хүчээр бэлгийн харьцаанд орсон гэж хариулсан байна.
- Харин анх бэлгийн харьцаанд орсон насаар ангилан үзэхэд 15 хүртэлх насанд бэлгийн харьцаанд орсон эмэгтэйчүүдийн **ихэнх нь хүчээр (61.0%) эсвэл хүсээгүй үедээ (14.3%)** бэлгийн харьцаанд орсон байна. Тэдний ердөө дөрөвний нэг нь л бэлгийн харьцаанд өөрөө хүсч орсон байна. Анх хүчээр бэлгийн харьцаанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15-17 насны бүлэгт мөн өндөр (11.9 хувь) байна.



Анх бэлгийн харьцаанд орохдоо хүсэж байсан эсэх, анх бэлгийн харьцаанд орсон насны бүлгээр






Бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хугацаагаар



Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүчирхийлэл үйлдэгч болон насны бүлгээр



Бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хугацаагаар



Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, үйлдэгч, насны бүлэг, хугацаагаар



БАЯРЛАЛАА

information@nso.mn

www.nso.mn

www.1212.mn

